УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН ТУШААЛ

2017 оны 08 сарын 03 өдөр Дугаар А/1024 Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.4 дэх заалт, Нийслэлийн засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан" Захирамжлалын бичиг баримт боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам"-ын 2 дугаар хэсгийн 2.4.1 дэх заалт, Улаанбаатар хотын захирагчийн ажлын албаны 2 дугаар хэсгийн 2.9.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас 2016 оны 07 дугаар сарын 20-ны өдөр "Асокин" ХХК-тай байгуулсан "Гадна зар сурталчилгааны байгууламжийн түрээсийн гэрээ", 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдөр "Алтан алим" ХХК-тай байгуулсан "Гадна зар сурталчилгааны байгууламжийн түрээсийн гэрээ"-г тус тус дүгнэх Ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

2. Ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн гадна зар сурталчилгааны байгууламж ашиглагч байгууллагатай холбогдох хууль журмын дагуу гэрээ байгуулах ажлыг зохион байгуулж, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтэс /Г.Уганбаяр/-т даалгасугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ~~ЗАХИРАГЧИЙН~~ АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА Т.ГАНТӨМӨР

D:\backup_old_pc\Work documents\doc 2017\tushaal 2017.docx

11103005??

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2017 оны 08 дугаар сарын 03 өдрийн
А/104 дүгээр тушаалын хавсралт

ГАДНА ЗАР СУРТАЛЧИЛГААНЫ БАЙГУУЛАМЖИЙН
ГЭРЭЭ ДҮГНЭХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга	Г.Уганбаяр	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн дарга
Гишүүд	М.Гансэлэм	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн
	Б.Цэрмаа	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны ахлах нягтлан бодогч
	Д.Лувсанчимэд	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Аудит дотоод хяналтын хэлтсийн дотоод хяналтын мэргэжилтэн
Нарийн бичгийн дарга	Г.Билгүүн	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн Гадна зар сурталчилгааны асуудал хариуцсан мэргэжилтэн